



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 2 сарын 18-ны өдөр

Дугаар 2022/04

Улаанбаатар хот

Ногдол ашиг тараах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2 сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгийн дүнгээс 30% (гучин хувь)-иар буюу 1,260,000,000 (нэг тэрбум хоёр зуун жаран сая) төгрөгийг мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 4.5 (дөрөв аравны тав) төгрөгийн ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг хүртэх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-иар зуучлуулан гүйцэтгүүлж, ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2022 оны 07 сарын 01-ний өдрийн дотор тараасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулж, төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хороонд үүрэг болгосугай.



Ч.ГАНХУЯГ